



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/11

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь "Зураг төсвийн сан"-аас санхүүжүүлэх шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 1 дүгээр, "Ажлын гүйцэтгэл"-ийн төсвөөс санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг, төслийн даалгавар, техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010015



Аймгийн Засаг даргын 2023 оны 01  
дүгээр сарын 11-ний өдрийн  
А/11.дугаар захирамжийн 1 дүгээр  
хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ  
“ЗУРАГ ТӨСВИЙН САН”-ААС САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР  
БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН  
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Галт сумын “Соёлын төв”-ийн /250 хүний хүчин чадалтай/ барилын ажлын зураг төсөл боловсруулах	40,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	Спорт заал /Мөрөн сум/ ажлын зураг төсөл боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Нэгдсэн эмнэлгийн төв барилгын засварын ажлын зураг төсөл боловсруулах	15,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
4	Жанхайн даваан дээр орон нутгийн иргэдийн худалдаа үйлчилгээ, явуулах боломжийг бүрдүүлсэн тохижилт бүхий цэг байгуулах ажлын зураг төсөл боловсруулах	8,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
5	Галт сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварын ажлын зураг төсөл боловсруулах	7,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
6	Чандмань-Өндөр сумын “Чандмань” цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын зураг төсөл боловсруулах	4,500,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	94,500,000	



Аймгийн Засаг даргын 2023 оны 01  
дүгээр сарын 11-ний өдрийн  
А/11-дугаар захирамжийн 2 дугаар  
хавсралт

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР БАРИХ,  
ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН “АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-  
ИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Бүрэнхаан сургуулийн баруун талын хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх /Сод эрдэм ЕБСургуулийн баруун талд 1.106 км хатуу хучилттай зам барих / ажлын зураг төсөл боловсруулах	9,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	“Хөвсгөлд үйлдвэрлэв” борлуулалтын нэгдсэн төв, брэнд бүтээгдэхүүн борлуулах цэгийн ажлын зураг төсөл боловсруулах	5,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Аялал жуулчлалын бүс, зам дагуу стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах	4,500,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
4	Намнагийн арын постын ажлын зураг төсөл боловсруулах	2,500,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
5	“Энх-Үйлс” өрхийн эрүүл мэндийн эмнэлгийн гадна хашаа барих (Мөрөн сум) ажлын зураг төсөл боловсруулах	800,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	21,800,000	